

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ

Тахько (ХК) компани Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдах шийдвэр гарч, Тахько хувьцаат компани (100 хувь хувийн өмчид шилжсэн) байгуулагдсан үеэс өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани 1992 онд буюу хувьчлагдах үеийн эхлэлтийн балансаар 345,567.5 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 592,830 ширхэг энгийн хувьцаатай байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 16,455,524 мянган төгрөгийн хөрөнгөтэй, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг бүр нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийтэд зарласан чөлөөтэй арилжаалагдах 1,189,983 ширхэг энгийн хувьцаатай нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр ажиллаж байна.

ХОЁР. 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн засаглал

Тахько (ХК) компанийн захиргаа (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгжийн албадууд) 2021 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Монголын компанийн засаглалын кодекс, стандартын шаардлагыг мөрдөж, засаглалын үйл ажиллагааг ил тод явуулж ажиллаж байна.

Компанийн захиргаа 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2020 оны санхүүгийн тайланд аудит хийлгэсэн Прайсуотерхаускуперс аудит компанийн дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, уг хурлыг онлайнаар зохион байгуулах, аудитын компани сонгох зэрэг асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан.

Компанийн захиргаа Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хуульд заасан хугацаа, төрийн зохицуулах байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн хийж, хүчин төгөлдөр саналын эрхийн 85.28 хувийн ирцтэйгээр хуралдуулж, хурлаар хэлэлцсэн Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дотоод



ажлын зардлын төсвийг батлах асуудлуудыг хуралд оролцогчдын 99,99-100 хувийн саналын эрхээр тус тус батлуулж шийдвэрлүүлсэн.

2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн 6, хараат бус 3 гишүүн сонгогдсон. Сонгогдсон гишүүд өмнө нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан, үүнээс хараат бус гишүүд нь Компанийн хуульд заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангаж байгаа бөгөөд сонгогдсон гишүүдийн тухай мэдээллийг Хөрөнгийн биржийн болон компанийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, холбогдох бусад баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хуульд заасан хугацаанд хүргүүлж, хууль тогтоомж, төрийн зохицуулах байгууллагаас гаргасан журам, хугацааны заалтыг хэрэгжүүлж ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (ТУЗ-ийн 2021.02.10-ны № 02 тогтоол)-ийн дагуу компанийн 2020 оны цэвэр ашгаас 1,189,983 ширхэг энгийн хувьцаанд хуваарилсан 128,518.1 мянган төгрөгийн ногдол ашгаас хувь хүн ба аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 6,700.0 мянган төгрөг суутган харьяалах татварын байгууллагад шилжүүлэн тайлагнаж, 121,591.3 мянган төгрөг (Үүнээс 116,770.6 мянган төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан, 4,820.7 мянган төгрөгийн ногдол ашгийг компани дээр тус тус олгож)-ийн ногдол ашгийг бүртгэлийн өдрөөр ногдол ашиг хүртэх эрхтэй 626 хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр байршуулж, хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд тайлагнасан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-20.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан Мэдээллийн ил тод байдлын журмын 1.2-1.3, 2.2, 3.1, 3.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 9/277 тоот бичгээр өгсөн үрэг, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн журмын 21.1-21.9, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны 01/13 тоот хамтран ажиллах бичгийн 1-8, мөн бичгийн хавсралт мэдээллийн 11 заалтыг тус тус хэрэгжүүлж санхүүгийн ба санхүүгийн бус тайлан, хугацаат ба тухай бүр мэдээлэх мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийт, холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд мэдээлэх үүргийг биелүүлж ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн чиглэл, нээлттэй хувьцаат компанийн хүлээсэн үүргийн дагуу зохицуулах байгууллагын зөвшөөрөлтэй Гэрэгэ эстимэйт ХХК-тай хөрөнгийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, компанийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хийлгэсэн.

Компанийн веб хуудасны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, компанийн бусад мэдээллийг мэдээлж, хувьцаа эзэмшигч болон олон нийтийг мэдээллээр хангах үүргийг биелүүлэн ажиллаж байна.

2021 онд их хэмжээний ба сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй, үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх нөхцөл байдал үүсч бий болоогүй болно.

Компани 2021 онд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн тогтоол, шийдвэр, журмаар тогтоосон нээлттэй хувьцаат компанийд холбогдох заалтууд болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Тахько (ХК) компани 2021 онд компанийн засаглалын зарчим, үйл ажиллагааг хэрэгжүүлж Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 12 дугаар зүйлийн 12.1-ийн 12.1.1-12.1.4, 12.2-ын 12.2.1-12.2.4 дэх хэсэгт заасан үнэт цаас гаргагч болон үнэт цаасны шалгуур (тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргах, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй аудитын байгууллагаар баталгаажуулах, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капиталтай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан, компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг, компанийн зах зээлийн үнэлгээ, гаргасан үнэт цаасны нийтэд санал болгосон хувь, компани нь засаглалын болон мэдээллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг)-ын дагуу хоёрдугаар ангилын нээлттэй компанийн шаардлагыг хангаж ажилласан.

Компанийн бүтэц, зохион байгуулалт

Компани 2021 онд Гүйцэтгэх удирдлага, Захиргааны болон Техник үйлчилгээний алба, Анкор төв гэсэн бүтэцтэй ажилласан.

Компанийн 2021 онд мөрдөх орон тоо, албан тушаалтны үндсэн цалингийн хэмжээг Гүйцэтгэх захирлын 2021.03.09-ний өдрийн 06 дугаар тушаалаар баталж, байнгын ажлын байрны 24 орон тоотой ажиллахаар төлөвлөж, 22 орон тоо (Нягтлан бодогч, сантехникийн засварчны орон тоонд хүн ажиллуулаагүй)-оор ажилласан.

Зөвлөх үйлчилгээний компаниас Хөдөлмөрийн эрх зүйн харилцааны талаар өгсөн зөвлөмжийг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2021 оны 08 дугаар тушаалаар компанийн байнгын ажлын байрны жагсаалт, ангилал, лавлах болон ажлын байрны албан тушаал бүрийн тодорхойлолтыг шинэчлэн баталж, мөрдөж ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан байнгын ажлын байрны жагсаалтаас 2 орон тоог хасч, уг ажлын байранд ажиллах хүнийг хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллуулдаг болсон.

Компанийн ажлын байрны ангилал, лавлах, тодорхойлолтыг шинэчлэн баталсны дагуу байнгын ажлын байранд ажилладаг 21 ажилтантай хөдөлмөрийн хугацаагүй ба нууцын, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг шинээр байгуулан ажиллаж байна.

Компанийн 2020 оны санхүүгийн тайланг “A” форматаар болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргаж, Прайсуотерхаускуперс аудит ХХК-аар олон улсын түвшний аудитын баталгаажуулалт хийлгэж, Төлөөлөн

удирдах зөвлөл болон 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулж, дүгнэлт тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн.

Компанийн дүрмээр олгосон эрх хэмжээний хүрээнд өмч хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой хангамжийн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатахуун худалдан авах, хөрөнгийн засвар хийх, үйлчилээ үзүүлэх зэрэг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 60 гэрээ байгуулж, тэдгээр гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, ажлын үр дүнг хүлээн авч, төлбөр тооцоог хийж дуусгасан.

Компанийн өмч хөрөнгийг эрсдэлээс хамгаалах зорилгоор Практикал даатгал компанитай үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ шинээр байгуулж, бүх төрлийн даатгалын гэрээнүүдийн дагуу 2021 оны даатгалын хураамжинд 12,319.0 мянган төгрөг төлсөн.

Оёдлын үйлдвэр, компаниас өндөр насын тэтгэвэрт гарсан Хөдөлмөрийн баатар, гавьяат ажилтан болон өндөр настай 18 ахмад настанд цагаан сарын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж, ахмад настан Хөдөлмөрийн баатар 2, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан 1, гачигдал тохиолдсон ахмад настан 7 хүнд нийтдээ 2,217.0 мянган төгрөгийн буцалтгүй тэтгэмж, тусламж олгосон байна.

Компанийн Акор төвд шинэ жилийн ба захиалгат 11 удаагийн 66 цагийн арга хэмжээний үйлчилгээ үзүүлж, 32,128.6 мянган төгрөгийн орлоготой ажилласан.

Хүний нөөц, нийгмийн хариуцлагын асуудал

Компани тайлангийн хугацаанд 22 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, Хөдөлмөрийн гэрээгээр тохиролцсон ажлын байрны үндсэн цалингийн хэмжээг мөрдөж, тэдний ажлын үр дүнг харгалзан Гүйцэтгэх захирлын 2016 оны 16 тоот тушаалаар баталсан Цалингийн урамшуулал олгох журмын дагуу улиралд нэг удаа үндсэн цалингийн 40 хүртэл хувийн урамшуулал олгож байна.

Гүйцэтгэх удирдлагыг удирдлагын коучинг, гүйцэтгэлийн удирдлага, манлайллын, Ерөнхий нягтлан бодогчийг аудитор, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй боловсрол ба тасралтгүй хөгжил, менежер нэг ажилтныг бизнесийн үндсэн ба компьютерийн, цахилгааны инженер, цахилгаанчдыг аюулгүй ажиллагааны эрх сунгах сургалтуудад хамруулж мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлсэн. Сургалтад 8,368.0 мянган төгрөг зарцуулсан.

2021 онд ажилтнууд, удирдлага, ТУЗ-ын гишүүдийн цалин хөлс, урамшуулалд нийтдээ 945,711.0 мянган төгрөг олгож, цалингийн зардал компанийн нийт зардлын 40 хувь болсон.

Нийт ажилтнуудын ажлыг Хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтын чиг үүргийн дагуу улирал тутам дүгнэж, 2021 онд ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн ажил үүрэг, хөдөлмөрийн гэрээ, дотоод журмын зарим заалтыг бүрэн биелүүлээгүй гэж үзсэн 5 ажилтан (нэг менежер, нэг цахилгаанчин, хоёр засварчин, нэг үйлчлэгч)-ны

цалингийн урамшууллыг 20-100 хувиар хасч ажлын хариуцлагыг дээшлүүлэх хөшүүрэг болгон ажилласан.

Хөдөлмөрийн гэрээнд ажлаас халахаар заасан сахилгын зөрчил гаргасан хоёр ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалж, хоёр ажилтны үндсэн цалинг З сарын хугацаагаар 20 хувиар хасч, гурван ажилтанд сануулах сахилгын шийтгэл хүлээлгэсэн.

Гачигдал тохиолдсон Компанийн 12 ажилтанд нийт 10,389.0 мянган төгрөгийн буцалтгүй тусlamж олгож ахуй амьдралд нь туслалцаа, дэмжлэг үзүүлсэн. Үүний дотор корона вирусын халдварт авсан компанийн 6 ажилтны эмчилгээнд нь зориулан хүн тус бүрт 250.0 төгрөгийн тусlamж үзүүлж, ажилтнуудыг корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх журмыг Гүйцгэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөж, ажилтнуудыг ээлжээр ажиллуулах, ажлын цагийг богиносгох арга хэмжээ авч ажилласан.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр гамшгаас хамгаалах Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж хөл хороо тогтоосон хугацаанд ажилдаа ирээгүй ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтын дагуу 17,772.0 мянган төгрөгийн олговор олгосон.

Мөн Засгийн газрын шийдвэрийн дагуу 2021 онд компанийн нийт ажиллагсад нийгмийн даатгалын шимтгэл төлөх дүнгээс 9,335 мянган төгрөг, Компани 16,389 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс чөлөөлөгдсөн байна.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нутаг дэвсгэрийн төр, захиргаа, онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагаас өмчлөгч-ерөнхий түрээсэлэгчийн хувьд Тахько компанийд тавьж буй шаардлагын дагуу MA-I, MA-II, U-I барилгуудыг түрээсээр эзэмшиж байгаа Мобиком корпораци, Ньюком проперти, Скайтел ХХК-дад ковид-19 өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ариутгал халдвартгүйжилтийн ажил хийх, иргэд, үйлчлүүлэгчдийг нэвтрүүлэх талаар өгч байгаа журам зааврыг хэрэгжүүлж ажиллах талаар мэдэгдэл шаардлага өгөх, хяналт тавих зэргээр өдөр тутмын зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж ирсэн.

Компанийн ажилтнуудыг цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор оффис, анкор төв, цахилгаан, дулааны үзэль, ээлжийн цахилаанчин, сантехникчдийн өрөө, гарааш, агуулахын байруудад мэргэжлийн байгууллагаар 6 удаа ариутгал халдвартгүйжүүлэлт хийлгэж, ажилтнуудыг нэг удаагийн ам, нүүрний хаалт, бээлий, гар ариутгагчаар хангаж, шаардлагатай үед хэрэглэх халат, комбинзон, эм, ариутгалын бодис, амны хаалт, бээлийний нөөц бэлтгэсэн.

Ажилтнуудыг вакцинд бүрэн хамруулах, шаардлагатай үед түргэвчилсэн болон PCR шинижлгээ, эсрэг биетийн шинжилгээ хийлгэх, ажилд ирэх бүрт биеийн халууныг үзэх ажлын цагаар гадуур явж ажилласан болон гаднаас ирж ажилласан хүмүүсийн бүртгэл хөтөлж, QR код уншуулдаг болсон. Зарим ажилтны ажиллах цагийг зөрүүлэх, ээлжээр ажиллуулах, ажлын цагийг богиносгох зэргээр халдварын эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авч ажиллаж байна.

Тус компанийн байрыг дамжуулан түрээслэгч-жижиг бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа зогсож, тасалдсан, тэднээс байнга тавьж буй санал хүсэлтийг судлан үзэж Ерөнхий түрээслүүлэгч Тахько (ХК) компани, Ерөнхий түрээслэгч Ньюком проперти, Скайтел ХХК-тай харилцан тохиролцож, гамшигаас хамгаалах бүх нийтийн ба өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн эсэхийг үл харгалзан 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл МА-I барилга (Скайтел үйлчилгээний төв)-ын 2 дугаар давхар, МА-II барилга (ТЕДИ төв)-ын 2, 3, 4 дүгээр давхрын түрээсийн сарын төлбөрт 15 хувиар хөнгөлөлт үзүүлж, Ньюком проперти ХХК-ийн хувьд мөн хугацаанд эрх бүхий байгууллагаас Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааны түрээсийн төлбөрөөс 100 хувь чөлөөлсөн. Үүний дагуу ерөнхий түрээслэгч Ньюком проперти, Скайтел ХХК-үүд дамжуулан түрээслэгч нарын түрээсийн төлбөрийг мөн адил 15 хувиар хөнгөлж, жижиг бизнес эрхлэгч, талбай түрээслэгчдэд нийтдээ 30 хувийн хөнгөлөлт үзүүлсэн.

Тахько (ХК) компани нийтдээ 227,159.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрөөс чөлөөлж, Засгийн газар, Улсын ба Нийслэлийн Онцгой комиссын шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монголын жижиг хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн холбоо НҮТББ, Говь-Алтай аймгийн Залуучуудын холбоо, Хантайшир бөхийн дэвжээ ТББ, Нийслэлийн онцгой байдлын газар, иргэн Б.Найдалаа зэрэг байгууллага хүмүүст 31,500.0 мянган төгрөгийг хандив туслалцаа үзүүлсэн.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагын хүрээнд компаниас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудын санаачлага, оролцоотойгоор Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, Жамсрангийн Самбуугийн нэрэмжит гудамжны Тахько (ХК) компанийн арын нийтийн эзэмшлийн ногоон байгууламж бүхий цэцэрлэгийн сул талбайд 1,210 ширхэг хайлаасны бут, гацуур, голт бор тарьж, дүүргийн тохижилт үйлчилгээний байгууллагад хүлээлгэн өгсөн.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

Компанийн орлого нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр

Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор ахуйн хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр тууштай ажиллаж байгаа бөгөөд төслийн ажилд шаардлагатай судалгаа хийх, холбогдох материалуудыг бэлтгэх ажлуудыг хийж байна.

Улс орны хэмжээнд гамшигаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон, улсын хилээр гарах орох хөдөлгөөнийг хязгаарласан, зарим байгууллагын үйл ажиллагаа зогссон тул компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх талаар төлөвлөсөн ажлууд хийгдээгүй байна.

цалингийн урамшууллыг 20-100 хувиар хасч ажлын хариуцлагыг дээшлүүлэх хөшүүрэг болгон ажилласан.

Хөдөлмөрийн гэрээнд ажлаас халахаар заасан сахилгын зөрчил гаргасан хоёр ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалж, хоёр ажилтны үндсэн цалинг З сарын хугацаагаар 20 хувиар хасч, гурван ажилтанд сануулах сахилгын шийтгэл хүлээлгэсэн.

Гачигдал тохиолдсон Компанийн 12 ажилтанд нийт 10,389.0 мянган төгрөгийн буцалтгүй тусlamж олгож ахуй амьдралд нь туслалцаа, дэмжлэг үзүүлсэн. Үүний дотор корона вирусын халдварт авсан компанийн 6 ажилтны эмчилгээнд нь зориулан хүн тус бүрт 250.0 төгрөгийн тусlamж үзүүлж, ажилтнуудыг корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх журмыг Гүйцгэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөж, ажилтнуудыг ээлжээр ажиллуулах, ажлын цагийг богиносгох арга хэмжээ авч ажилласан.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр гамшгаас хамгаалах Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж хөл хороо тогтоосон хугацаанд ажилдаа ирээгүй ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтын дагуу 17,772.0 мянган төгрөгийн олговор олгосон.

Мөн Засгийн газрын шийдвэрийн дагуу 2021 онд компанийн нийт ажиллагсад нийгмийн даатгалын шимтгэл төлөх дүнгээс 9,335 мянган төгрөг, Компани 16,389 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс чөлөөлөгдсөн байна.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нутаг дэвсгэрийн төр, захиргаа, онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагаас өмчлөгч-ерөнхий түрээсэлэгчийн хувьд Тахько компанид тавьж буй шаардлагын дагуу MA-I, MA-II, U-I барилгуудыг түрээсээр эзэмшиж байгаа Мобиком корпораци, Ньюком проперти, Скайлел ХХК-дад ковид-19 өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ариутгал халдвартгүйжилтийн ажил хийх, иргэд, үйлчлүүлэгчдийг нэвтрүүлэх талаар өгч байгаа журам зааврыг хэрэгжүүлж ажиллах талаар мэдэгдэл шаардлага өгөх, хяналт тавих зэргээр өдөр тутмын зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж ирсэн.

Компанийн ажилтнуудыг цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор оффис, анкор төв, цахилгаан, дулааны үзэль, ээлжийн цахилаанчин, сантехникчдийн өрөө, гараш, агуулахын байруудад мэргэжлийн байгууллагаар 6 удаа ариутгал халдвартгүйжүүлэлт хийлгэж, ажилтнуудыг нэг удаагийн ам, нүүрний хаалт, бээлий, гар ариутгагчаар хангаж, шаардлагатай үед хэрэглэх халат, комбинзон, эм, ариутгалын бодис, амны хаалт, бээлийний нөөц бэлтгэсэн.

Ажилтнуудыг вакцинд бүрэн хамруулах, шаардлагатай үед түргэвчилсэн болон PCR шинижлгээ, эсрэг биетийн шинжилгээ хийлгэх, ажилд ирэх бүрт биеийн халууныг үзэх ажлын цагаар гадуур явж ажилласан болон гаднаас ирж ажилласан хүмүүсийн бүртгэл хөтөлж, QR код уншуулдаг болсон. Зарим ажилтны ажиллах цагийг зөрүүлэх, ээлжээр ажиллуулах, ажлын цагийг богиносгох зэргээр халдварын эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авч ажиллаж байна.

Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр

Их засварын ажил

Гүнт дэх эзэмшил газарт 250 кВА хүчин чадалтай цахилгааны КТПН шинээр суурилуулах ажлыг тусгай зөвшөөрөл бүхий Идэртэс ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн. Ажил гүйцэтгэх явцад техникийн нөхцөлийг шинээр гаргуулан КТПН-ийг хүчдэлд холбож, улсын комисст хүлээлгэж өгөх ажлууд хийгдэж дууссан.

Урсгал засварын ажил

Гүнт дэх барилга руу шинээр суурилуулсан КТПН-ээс 380 В-ын кабель татах, ХТП-477 дэд өртөөний графикт засвар, Анкор төвийн өрөөний тааз засварлах, дулааны тоолуурууд баталгаажуулах, агуулахын барилгын хаалга солих, ариун цэврийн өрөөний засвар, МА-I барилгын дэргэдэх авто гараашийн дотор хана, тавиур хийж агуулахын зориулалтаар засварлах, МА-II, У-I барилгын цахилгааны ерөнхий самбурууд, МА-I, МА-II, Анкор төвийн барилгын цахилгаан төхөөрөмж, МА-I, МА-II, У-I барилгын сантехник, дулааны 1, 2 дугаар контурын ялтаст бойлеруудын угаалт, шахалт хийх зэрэг 120,808.0 мянган төгрөг (үүнээс 75,955.0 мянган төгрөгийн барилгын, 16,644.0 мянган төгрөгийн цахилгааны, 28,209.0 мянган төгрөгийн сантехникийн)-ийн урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн.

Хэвийн үйл ажиллагааг хангах өдөр тутмын ажил

Цахилгаан эрчим хүчний гадаад, дотоод тооцооны нийт 50 гаруй тоолуурын заалтаар цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоог тогтмол хийж, 261,124.0 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчний үнийг хэрэглэгчдэд хувиарлан төлүүлсэн. Үндд: цахилгаан 231,525.0, цахилгааны тоолуурын зөрүү 7,668.0, тарифийн зөрүү 16,606.0, үйлчилгээний үнэ 5,325.0 мянган төгрөгийг хэрэглэгчдэд хуваарилж төлбөрийг хийлгэсэн.

Дулааны төлбөрт 52,607.0, үйлчилгээний төлбөрт 1,041.0, цэвэр бохир усны үйлчилгээний төлбөрт 360.0, усны төлбөрт 18,701.0, телефон ярианы төлбөрт 68.0 мянган төгрөгийн төлбөрүүдийг хэрэглэгчид хуваарилан төлүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдлын шимтгэл, сэлбэг, аж ахуй, барилга, хангамж, шатах тослох материал, кассын тооцоонд хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийлгэж, тайлан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласанаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй.

Ажлын байр, ажиллах нөхцөл, аюулгүй ажиллагааг хангах болон бусад

Ажлын байрны нөхцөлийг хангах зорилгоор 377,177.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч бэлтгэсэн.

Оффисын өрөөнүүдэд иж бүрэн урсгал засвар хийж, оффисын тавилгыг бүхэлд нь сольж, нэг өрөөнд олуулаа ажиллаж байсныг өөрчилж, нэг ажилтанд ногдох талбайг нэмэгдүүлж ажилтнуудын ажлын байрны нөхцөлийг сайжруулсан.

Компанийн оффисын болон мэдээллийн системийн хэвийн сааталгүй ажиллагааг хангах зорилгоор Ай Ти аутсорсинг ХХК-тай гэрээгээр хамтран ажиллаж, интернет, компьютерын болон камерын төхөөрөмж, Wireless access point төхөөрөмж, Unifi controller серверийн өдөр тутмын үйлчилгээ хийлгэн ажиллаж байна. Майкрософт оффис 365, антивирусын программын хугацаа, лицензүүдийг сунгах, домайн нэрийн төлбөр хийх, windows сервер болон компьютерүүдийн үйлдлийн систем, оффисын программуудыг лицензтэй болгож, сүлжээнд firewall төхөөрөмж суурилуулж, аж ахуйн агуулахад камер суурилуулан интернетэд холбож зайнаас хянах, тэдгээрийн найдвартай ажиллагааг хангах зэрэг сүлжээний тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний ажлыг 16,132.0 мянган төгрөгийн зардлаар хийж гүйцэтгэсэн.

Тайлангийн хугацаанд ажлын байрны аюулгүй ажиллагааг өдөр тутам хангаж ажилласнаар компанийн цахилгаан, өндөр хүчдэлийн шугам сүлжээ, хөдөлмөрийн ба галын аюулгүй ажиллагааны талаар зөрчил, дутагдал гараагүй болно. Анкор төв болон Гурвалжин дахь агуулахын барилгын галын аюулгүй байдлын дүгнэлтийг тус тус шинээр гаргуулсан.

Компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбогдсон санхүүгийн тайлан, татварын тайлан, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан болон бусад төрийн байгууллагад тайлагнадаг статистик мэдээ, тайлангуудыг хуульд заасан хугацаанд гаргаж, илгээсэн (тушаасан) болно. Манай компани 2021 онд улсын төсөвт 516,260.5 мянган төгрөг төлөхөөс 94.3 хувийг тайлангийн хугацаанд төлж барагдуулсан.Үүнд:

- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татвар 171,838.0 мянган төгрөг
- ✓ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 15,485.0 мянган төгрөг
- ✓ Хувь хүний орлогын албан татвар 88,572.6 мянган төгрөг
- ✓ Нийгмийн даатгалын шимтгэл 177,727.0 мянган төгрөг үүнд:
 - Даатгуулагч 68,368.0 мянган төгрөг
 - Ажил олгогч 109,359.0 мянган төгрөг
- ✓ Үл хөдлөх хөрөнгийн татвар 7,330.0 мянган төгрөг
- ✓ Газрын төлбөрт 19,029.9 мянган төгрөг
- ✓ Авто тээврийн өөрөө явах хэрэгслийн албан тавар, агаарын бохирдол болон зам ашигласны төлбөр 719.3 мянган төгрөг
- ✓ Ногдол ашгаас суутгасан татвар 6,164.4 мянган төгрөг бүгд 486,866.2 мянган төгрөг төлсөн.

Компани 2021 онд 3,091,223.0 мянган төгрөгийн орлоготой, 2,695,114.0 мянган төгрөгийн зарлагатай, 565,140.0 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, 2020 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого 53,247.0 мянган төгрөг буюу 2 хувиар буурч, зардал 90,334 мянган төгрөг буюу 3 хувиар өсч, хуримтлагдсан ашиг 5,805,755.0 мянган төгрөг болж 8 хувиар өссөн байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ АЛБАНЫ ДАРГА  ДОРЖГОТОВ

ХЯНАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 Л.ЭНХНАСАН